



Бурхан бол бидний Найз Залбирлын Хуудас

Огноо:

- Залбирлын хуудсыг хүн бүрт хувилж өгнө
- Цагтаа эхэлж, цагтаа дуусгана
- Хэрэгтэй зүйлс: Библи, *Ээжүүд Хамтдаа Залбирах нь Товхимол*, үзэг.

♥ **Магтаал** — Бурханыг **Хэн болохынх нь** төлөө, Түүний мөн чанар, Түүний нэр эсвэл Түүний зан чанарынх нь төлөө магтана. Энэ мөчид залбирлын хариулт болон залбирлын хүсэлтүүдээ хэлэхгүй.

Мөн чанар: Бурхан бол бидний Найз

Attribute: God Is Our Friend

Тодорхойлолт: Сэтгэл алдран хүндлэлээр татагдсан Нэгэн, дэмжигч, итгэмжлэгдсэн Нэгэн.

Эшлэл(үүд):

- **Иохан 15:13-15** Нөхдийнхөө төлөө амиа зориулахаас илүү агуу хайр байхгүй. Та нар тушаасныг минь үйлдвээс Миний нөхөд мөн. Би та нарыг боолууд гэж дахиж дуудахгүй. Учир нь эзнийхээ юу хийж байгааг боол эс мэдэх юм. Харин Би та нарыг анд нөхөд гэж дуудав. Учир нь Би Эцэгээсээ сонссон бүхнээ та нарт мэдүүлсэн билээ.
- **Иаков 2:23** “Бурханд Абрахам итгэсэн. Үүгээр нь түүнийг зөвд тооцсон юм” гэж өгүүлдэг Бичвэр биелэгдсэн бөгөөд Бурханы анд нөхөр гэж Абрахам дуудагдах болсон.
- **Лук 5:20** Итгэлийг нь харсан Есүс —Анд минь, нүгэл чинь уучлагдсан гэхэд

♥ **Гэмшил** — Уучилж өршөөдөг Бурханд хандан гэм нүглээ чимээгүй улайх.

Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ. 1 Иохан 1:9

♥ **Талархал** — **Хийсэн зүйлийх нь** төлөө Бурханд талархах. Энэ цагт залбирлын хүсэлтээ хэлэхгүй байх хэрэгтэй. *Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн. 1 Тесалоник 5:18*

♥ **Зуучлан залбирал** — Бурханы өмнө ирж бусдын төлөө залбирах. Хоёр буюу гурваар бүлэгт хуваагдана.

Өөрсдийн хүүхдүүдийн төлөө — Ээж бүр нэг хүүхэд сонгоно. (Библийн ишлэлээр залбирах/Залбирлын тодорхой хүсэлт)

Эшлэл(үүд): *Сургаалт үгс 12:26, 17:17; Ром 12:10*

Библийн эшлэлээр залбирах:

(Хүүхдийн нэр) маань өөрийн найз нөхдөө болгоомжтойгоор сонгон авдаг байх болтугай, мөн үргэлж хайрладаг найз байх болтугай. (Хүүхдийн нэр) маань найз нөхдийгөө ахан дүүс шигээ гүнээ хайрлах болтугай, бусдыг өөрөөсөө илүүд үзэн хүндэлдэг хүн болох болтугай.

Залбирлын тодорхой хүсэлт:

Багш/Ажилчид (нэгийг сонгоно): Багш/Ажилтаны төлөө залбирах нэг эшлэл сонго. Дараа нь тодорхой нэг хүсэлтийн дагуу залбирна.

- Эзэн минь ээ Та _____-ний нүдийг нээж, түүнийг харанхуйгаас гэрэл уруу, Сатаны эрхшээлээс Бурхан уруу эргүүлээч. Тэгснээрээ тэд Таньд итгэх итгэлээр ариусгагдсан хүмүүсийн дунд нүглийн уучлал ба өвийг хүртэх болно. *Үйлс 26:18*
- _____ маань өөрийн найз нөхдөө болгоомжтойгоор сонгон авдаг байх болтугай, мөн үргэлж хайрладаг найз байх болтугай. _____ маань найз нөхдийгөө ахан дүүс шигээ гүнээ хайрлах болтугай, бусдыг өөрөөсөө илүүд үзэн хүндэлдэг хүн болох болтугай. *Сургаалт үгс 12:26, 17:17; Ром 12:10*

Сургуулийн төлөө залбирах – Сургуулийн орчинд сэргэлт ирж, сүнсний хараа өгөгдөхийн төлөө (цаг байвал хамгаалалт гэх мэт өөр бусад сэдвүүдийн төлөө)

Ээжүүд Хамтдаа Залбирах нь үйлчлэлийн төлөө залбирах — Сургууль бүрийг залбирлаар хучих; үйлчлэлийг хамгаалж өө сэвгүй, цэвэр ариунаар хадгалах.

Бүлэгт залбирсан бүхэн зөвхөн бүлэг дотроо л үлдэх ёстойг анхаараарай!